

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/67/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413      Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055      Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас: 99177546      Цахим хаяг: <a href="mailto:Bujinkhandj@audit.gov.mn">Bujinkhandj@audit.gov.mn</a> Аудитор: Б.Цэвэлмаа Утас:99026016      Цахим хаяг: <a href="mailto:Tsevelmaab@audit.gov.mn">Tsevelmaab@audit.gov.mn</a></p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал .....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт .....	14
4.1 Залруулсан алдаа .....	14
4.2 Төлбөрийн акт.....	14
4.3 Албан шаардлага .....	14
4.4 Зөвлөмж.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.22

№

05

танай

-ны №

-т

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБЯАР

07020032

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>18,459,407.61</b>	<b>11,286,421.40</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>4,085,042.61</b>	<b>3,576,556.40</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,916,872.61	3,221,126.40
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>168,170.00</b>	<b>0.00</b>
33520	Хувь хүмүүсээс авах авлага	168,170.00	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>14,374,365.00</b>	<b>7,709,865.00</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>2,931,300.00</b>	<b>3,984,800.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	2,931,300.00	3,984,800.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>11,443,065.00</b>	<b>3,725,065.00</b>
35410	Бичиг хэргийн материал	999,200.00	781,650.00
35420	Аж ахуйн материал	9,765,165.00	2,603,415.00
35430	Сэлбэг хэрэгсэл	580,000.00	0.00
35440	Түлш, шатах тослох материал	13,700.00	0.00
35450	Барилгын засварын материал	85,000.00	340,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>133,525,665.75</b>	<b>207,121,769.14</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>133,525,665.75</b>	<b>207,121,769.14</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>107,525,665.75</b>	<b>181,121,769.14</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	61,546,443.00	115,597,843.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-28,665,122.56	-31,893,107.20
39203	Авто-тээврийн хэрэгсэл	20,600,000.00	20,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-20,600,000.00	-20,600,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	69,895,835.00	100,106,635.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-22,530,461.22	-24,794,613.73
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,968,752.08	14,226,036.08
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,614,522.29	-10,749,914.35
39214	Бусад үндсэн хөрөнгө	22,406,881.14	22,406,881.14
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,482,139.40	-3,777,990.80
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>26,000,000.00</b>	<b>26,000,000.00</b>
39301	Програм хангамж	480,000.00	480,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-480,000.00	-480,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	26,000,000.00	26,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>151,985,073.36</b>	<b>218,408,190.54</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,534,090.47</b>	<b>0.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,534,090.47</b>	<b>0.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>1,534,090.47</b>	<b>0.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	314,184.00	0.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,219,906.47	0.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>150,450,982.89</b>	<b>218,408,190.54</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>150,450,982.89</b>	<b>218,408,190.54</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	79,909,440.14	79,909,440.14
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>63,328,531.16</b>	<b>131,285,738.81</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-2,532,505.55	63,328,531.16
51220	Тайлант үеийн үр дүн	65,861,036.71	67,957,207.65
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,213,011.59	7,213,011.59
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>151,985,073.36</b>	<b>218,408,190.54</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>311,281,955.00</b>	<b>382,047,260.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>42,294,455.00</b>	<b>37,495,021.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>42,294,455.00</b>	<b>37,495,021.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>42,294,455.00</b>	<b>37,495,021.00</b>

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	41,162,455.00	36,065,060.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	1,132,000.00	1,429,961.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>268,987,500.00</b>	<b>337,194,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>268,987,500.00</b>	<b>337,194,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	268,987,500.00	337,194,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>0.00</b>	<b>7,357,739.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	7,357,739.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>245,420,918.29</b>	<b>314,090,052.35</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>245,420,918.29</b>	<b>314,090,052.35</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>243,620,324.86</b>	<b>291,650,521.33</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>144,051,444.96</b>	<b>160,978,031.19</b>
210101	Үндсэн цалин	106,477,433.84	119,593,016.11
210102	Нэмэгдэл	33,762,512.11	37,227,015.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,811,499.01	4,157,999.53
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>19,955,700.00</b>	<b>20,269,700.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	14,042,900.00	14,263,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,478,200.00	1,501,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,182,600.00	1,201,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	295,600.00	300,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,956,400.00	3,002,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>6,432,859.47</b>	<b>7,210,301.53</b>
210301	Гэрэл, цахилгаан	920,693.47	864,741.53
210302	Түлш, халаалт	5,333,526.00	5,982,560.00
210303	Цэвэр, бохир ус	178,640.00	363,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>15,406,386.00</b>	<b>21,439,283.00</b>
210401	Бичиг хэрэг	3,465,150.00	2,475,250.00
210402	Тээвэр, шатахуун	6,386,288.00	5,441,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	870,000.00	1,270,433.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	130,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,736,500.00	5,307,000.00
210408	Бараа материал акалсны зардал	948,448.00	6,815,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,000,400.00</b>	<b>479,500.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,000,400.00	420,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	59,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,103,675.00</b>	<b>22,989,300.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	139,500.00	390,000.00
210604	Урсгал засвар	5,964,175.00	22,599,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>12,417,000.00</b>	<b>10,824,900.00</b>
210702	Дотоод албан томилолт	12,417,000.00	10,824,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>22,213,650.00</b>	<b>23,428,820.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,476,660.00	22,816,360.00
210803	Даатгалын үйлчилгээ	220,000.00	220,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,000.00	51,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	113,000.00	28,560.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	8,040.00	5,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	311,950.00	274,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>16,039,209.43</b>	<b>24,030,685.61</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,615,500.00	6,626,989.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	742,780.00	637,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,680,929.43	16,766,496.61
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,800,593.43</b>	<b>22,439,531.02</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>600,000.00</b>	<b>16,427,456.00</b>

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	15,947,456.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	480,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,200,593.43</b>	<b>6,012,075.02</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,200,593.43	6,012,075.02
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>65,861,036.71</b>	<b>67,957,207.65</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>65,861,036.71</b>	<b>67,957,207.65</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	79,909,440.14	7,213,011.59	-2,532,505.55	84,589,946.18
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>79,909,440.14</b>	<b>7,213,011.59</b>	<b>-2,532,505.55</b>	<b>84,589,946.18</b>
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	65,861,036.71	65,861,036.71
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>79,909,440.14</b>	<b>7,213,011.59</b>	<b>63,328,531.16</b>	<b>150,450,982.89</b>
<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>79,909,440.14</b>	<b>7,213,011.59</b>	<b>63,328,531.16</b>	<b>150,450,982.89</b>
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>79,909,440.14</b>	<b>7,213,011.59</b>	<b>63,328,531.16</b>	<b>150,450,982.89</b>
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	67,957,207.65	67,957,207.65
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>79,909,440.14</b>	<b>7,213,011.59</b>	<b>131,285,738.81</b>	<b>218,408,190.54</b>

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>310,149,955.00</b>	<b>380,261,869.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>41,162,455.00</b>	<b>35,709,630.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>41,162,455.00</b>	<b>35,709,630.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>41,162,455.00</b>	<b>35,709,630.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	41,162,455.00	35,709,630.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>268,987,500.00</b>	<b>344,552,239.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>268,987,500.00</b>	<b>337,194,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	268,987,500.00	337,194,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>0.00</b>	<b>7,357,739.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	7,357,739.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>240,320,336.00</b>	<b>289,899,269.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>240,320,336.00</b>	<b>289,899,269.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>238,519,742.57</b>	<b>267,459,737.98</b>

<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>147,819,699.57</b>	<b>160,428,298.98</b>
210101	Үндсэн цалин	108,757,019.45	118,729,099.90
210102	Нэмэгдэл	34,904,681.11	37,541,199.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,157,999.01	4,157,999.53
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>19,955,700.00</b>	<b>20,269,700.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	14,042,900.00	14,263,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,478,200.00	1,501,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,182,600.00	1,201,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	295,600.00	300,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,956,400.00	3,002,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>7,870,300.00</b>	<b>7,255,108.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	875,887.00	909,548.00
210302	Түлш, халаалт	6,815,773.00	5,982,560.00
210303	Цэвэр, бохир ус	178,640.00	363,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>13,919,988.00</b>	<b>12,719,783.00</b>
210401	Бичиг хэрэг	2,900,000.00	2,248,350.00
210402	Тээвэр, шатахуун	6,399,988.00	5,441,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	870,000.00	1,270,433.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	130,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,750,000.00	3,630,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>3,499,800.00</b>	<b>2,279,500.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,000,000.00	420,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,499,800.00	1,859,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,679,875.00</b>	<b>21,814,339.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	320,000.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	250,000.00	390,000.00
210604	Урсгал засвар	6,109,875.00	21,424,339.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>12,085,900.00</b>	<b>12,000,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	12,085,900.00	12,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>22,235,200.00</b>	<b>23,428,820.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,476,660.00	22,816,360.00
210803	Даатгалын үйлчилгээ	220,000.00	220,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,000.00	51,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	113,000.00	28,560.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	8,040.00	5,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	333,500.00	274,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,453,280.00</b>	<b>7,264,189.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,710,500.00	6,626,989.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	742,780.00	637,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,800,593.43</b>	<b>22,439,531.02</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>600,000.00</b>	<b>16,427,456.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	15,947,456.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	480,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,200,593.43</b>	<b>6,012,075.02</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,200,593.43	6,012,075.02
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>69,829,619.00</b>	<b>90,362,600.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>69,829,619.00</b>	<b>90,362,600.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>69,829,619.00</b>	<b>90,362,600.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>69,829,619.00</b>	<b>90,362,600.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	69,829,619.00	90,362,600.00

VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-69,829,619.00	-90,362,600.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Тайлант оны	Цэвэр гүйцэтгэл	Төсвийн хэмнэлт+, хэмнэлт-	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>372,694,500.00</b>	<b>366,892,054.98</b>	<b>5,802,445.02</b>	<b>98%</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>372,694,500.00</b>	<b>366,892,054.98</b>	5,802,445.02	98%
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>356,267,000.00</b>	<b>350,464,598.98</b>	5,802,401.02	98%
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	159,275,100.00	159,275,098.98	1.02	100%
Үндсэн цалин	117,575,900.00	117,575,899.90	0.10	100%
Нэмэгдэл	37,541,200.00	37,541,199.55	0.45	100%
Унаа хоолны хөнгөлөлт	4,158,000.00	4,157,999.53	0.47	100%
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	20,269,700.00	20,269,700.00	-	100%
Тэтгэврийн даатгал	14,263,800.00	14,263,800.00	-	100%
Тэтгэмжийн даатгал	1,501,500.00	1,501,500.00	-	100%
ҮОМШӨ-ний даатгал	1,201,200.00	1,201,200.00	-	100%
Ажилгүйдлийн даатгал	300,300.00	300,300.00	-	100%
Эрүүл мэндийн даатгал	3,002,900.00	3,002,900.00	-	100%
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	7,418,600.00	7,255,108.00	163,492.00	98%
Гэрэл, цахилгаан	1,092,600.00	909,548.00	183,052.00	83%
Түлш, халаалт	5,841,800.00	5,982,560.00	(140,760.00)	102%
Цэвэр, бохир ус	484,200.00	363,000.00	121,200.00	75%
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	12,840,100.00	12,719,783.00	120,317.00	99%
Бичиг хэрэг	2,248,700.00	2,248,350.00	350.00	100%
Тээвэр, шатахуун	5,441,000.00	5,441,000.00	-	100%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,271,000.00	1,270,433.00	567.00	100%
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	249,400.00	130,000.00	119,400.00	52%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,630,000.00	3,630,000.00	-	100%
<b>Нормативт зардал</b>	2,279,500.00	2,279,500.00	-	100%
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	420,000.00	420,000.00	-	100%
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,859,500.00	1,859,500.00	-	100%
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	113,304,000.00	107,793,200.00	5,510,800.00	95%
Багаж, техник, хэрэгсэл	36,312,000.00	36,311,200.00	800.00	100%
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	400,000.00	390,000.00	10,000.00	98%
Урсгал засвар	76,592,000.00	71,092,000.00	5,500,000.00	93%
<b>Томилолт, зочны зардал</b>	12,000,000.00	12,000,000.00	-	100%
Дотоод албан томилолт	12,000,000.00	12,000,000.00	-	100%
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	21,612,700.00	21,608,020.00	4,680.00	100%

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,000,000.00	20,995,560.00	4,440.00	100%
Даатгалын үйлчилгээ	220,000.00	220,000.00	-	100%
Тээврийн хэрэгслийн татвар	51,000.00	51,000.00	-	100%
Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00	-	100%
Газрын төлбөр	28,800.00	28,560.00	240.00	99%
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,000.00	5,000.00	-	100%
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	274,900.00	274,900.00	-	100%
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	7,267,300.00	7,264,189.00	3,111.00	100%
Бараа үйлчилгээний бусад зардал	6,630,100.00	6,626,989.00	3,111.00	100%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	637,200.00	637,200.00	-	100%
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	16,427,500.00	16,427,456.00	44.00	100%
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	16,427,500.00	16,427,456.00	44.00	100%
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,947,500.00	15,947,456.00	44.00	100%
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	480,000.00	480,000.00	-	100%
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>372,694,500.00</b>	<b>366,892,054.98</b>	<b>5,802,445.02</b>	<b>98%</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>337,194,500.00</b>	<b>331,654,324.98</b>	<b>5,540,175.02</b>	<b>98%</b>
Улсын төсвөөс санхүүжих	337,194,500.00	331,654,324.98	5,540,175.02	98%
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>35,500,000.00</b>	<b>35,237,730.00</b>	<b>262,270.00</b>	<b>99%</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,500,000.00	35,237,730.00	262,270.00	99%

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

ЭЗА	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>7,357,739.0</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	7,357,739.0
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	7,357,739.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	1,153,200.00
210101	Үндсэн цалин		1,153,200.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	4,383,739.00
210604	Урсгал засвар		4,383,739.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	1,820,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,820,800.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>7,357,739.0</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	7,357,739.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	7,357,739.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэвэлмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Стандарт, хэмжил зүйн хэлтэс нь нутаг дэвсгэрийнхээ боловсролын байгууллага, иргэдийг төрийн захиргааны болон мэргэжлийн удирдлагаар хангах, тэдний үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх чиг үүрэгтэй Стандарт, хэмжил зүйн үндэсний төвийн харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгасан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 245.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 4.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.9 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 44 хувиар буюу 66.4 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Авлага дансны үлдэгдэл 3.6 сая төгрөгийн 0.7 сая төгрөг нь нийгмийн даатгалын шимтгэлийн, 1.6 сая төгрөг нь ХХОАТ-ын, 0.4 сая төгрөг нь төлбөртэй үйлчилгээний, 0.9 сая төгрөг нь хувь хүнээс авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 7.7 сая төгрөг болж 6.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 35.4 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, шүүхийн шийдвэрээр төлүүлсэн 1.4 сая төгрөгийн бараа материал орлого авч, үйл ажиллагаандаа 36.7 сая төгрөгийн материалыг зарцуулж, 6.8 сая төгрөгийн бараа материалыг акталж данснаас хассантай холбоотой.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 299.4 сая төгрөг болж 82.5 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 90.4 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 7.8 сая төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 218.4 сая төгрөг болж 68.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 12.3 хувиар буюу 70.7 сая төгрөгөөр өссөн нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн орлого өссөнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 131.3 сая төгрөг болсон байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 324.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 48.1 сая төгрөгөөр бууруулж, 372.7 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс бага байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг бууруулж баталсантай холбоотой байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 1 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 372.7 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 337.2 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 35.7 сая төгрөгийн орлого олж, урсгал үйл ажиллагаанд 366.9 сая төгрөгийг зарцуулж 6.0 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 366.9 сая төгрөг буюу 98 хувьтай байгаа хангамж, бараа материалын зардлыг 0.1 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.2 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 5.5 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 7.4 сая төгрөгийн орлого хүлээн авч, 1.1 сая төгрөгийг цалин хөлс, урамшууллын зардалд, 4.4 сая төгрөгийг урсгал засварын зардалд, 1.8 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, худалдан авах ажиллагаа, худалдан авалтын и-баримтыг хяналаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс 169 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн, 2 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 3.9.2 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Санхүүгийн тайлангийн аудитаар тендерт шалгараагүй иргэн аж ахуйн нэгж байгууллагаас 70.6 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна” гэсэн заалттай нийцсэн байна.

#### 3.9.3 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд 2.0 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг дутуу шивүүлснийг аудитын явцад залруулсан.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7, Татварын ерөнхий хуулийн 28., 2-т " Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3 дахь заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.3 сая төгрөгийн төлбөрийн акт, зөрчил арилгах 1 албан шаардлагын хэрэгжилтийг хангуулсан байна.

### 3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараагийн аудитаар төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй. Тус байгууллага нь 0.5 сая төгрөгөөр Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг захиалж хийлгүүлснээс дүгнэхэд ТЕЗ-ын хүрээнд нэгдсэн журмаар шийдвэрлэж, төсвийг хэмнэж болохоор зардал байжээ. Мөн шүүхийн шийдвэрийн цалингийн нөхөн олговрын 23.9 сая төгрөгийг дээд шатны төсөв захирагчаас цалингийн

зардалд хуваарилж олгосныг санхүүгийн тайланд авлагаар тусгасан эсэхийг анхаарч үзэх шаардлагатай.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 13.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 12.6 сая төгрөгийн алдааг залруулж, 0.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

##### 4.1 Залруулсан алдаа

Бараа материалын тодруулга тайланг 4.9 сая төгрөгөөр зөрүүтэй, тайлант үеийн үр дүнг 5.8 сая төгрөгөөр дутуу тайлагнасныг аудитын явцад байгууллагын удирдлага, нягтлан бодогч хүлээн зөвшөөрч санхүүгийн тайланд залруулав. Зардлыг түүвэрлэн үзэхэд 2.0 сая төгрөгийн и-баримтгүй худалдан авалт хийсэн байсныг аудитын явцад нөхөж шивүүлсэн.

##### 4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал байхгүй.

##### 4.3 Албан шаардлага

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасныг зөрчсөн, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн тайланд нэгээс дээш жилийн насжилттай 0.9 сая төгрөгийн авлага бүртгэлтэй, барагдуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

##### 4.4 Зөвлөмж

Аудитаар илэрсэн 1 алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа. Үүнд:

#### 1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 130.2 сая төгрөгийн 18 орлогын гүйлгээг мэдээлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Стандарт, хэмжил зүйн хэлтэс	5	13.5	2	12.6	0	0	2	0.9	1	0